



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 11 сарын 27 өдөр

Дугаар А/66

Улаанбаатар хот

Нийслэлийн оны шилдэг багш,
дасгалжуулагч, тамирчин, арга
зүйч шалгаруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Засгийн газрын 2009 оны 05, 2017 оны 289 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:


1. Нийслэлийн оны шилдэг багш, дасгалжуулагч, тамирчин, арга зүйч шалгаруулах болзлын дагуу дүүргүүдийн Биеийн тамир, спортын хороодоос шалгаруулан ирүүлсэн хүмүүсийн материал, ажлын үзүүлэлт, үр дүнг үнэлж дүгнэн Нийслэлийн 2018 оны шилдэг багш, дасгалжуулагч, тамирчин, арга зүйч нарыг сонгон шалгаруулсугай.

2. Нийслэлийн 2018 оны шилдэг багш, дасгалжуулагч, тамирчин, арга зүйчээр шалгарсан хүмүүсийг шагнах шагналын төсвийг хавсралтаар баталсугай.

3. Шагналд шаардагдах 2.900.000 /хоёр сая есөн зуун мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны биеийн тамир, чийрэгжүүлэлтийн нийтийг хамарсан арга хэмжээний зардлаас гаргахыг нягтлан бодогч /Л.Төгөлдөр/-д зөвшөөрсүгэй.


4. Шалгаруулалтын арга хэмжээг зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтэс /А.Болдмаад/ үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны
даргын 2018 оны 11 дугаар сарын 27-ны өдрийн
А/б. дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Нийслэлийн оны шилдэг багш,
дасгалжуулагч, тамирчин, арга
зүйч шалгаруулах төсөв

№	Зардлын нэр	Зардлын хэмжээ /төг/	Нийт зардал /төг/
1.	Тэргүүний багш, дасгалжуулагч, тамирчин, арга зүйчийн шагнал	5x200.000	1000.000
2.	Цом, өргөмжлөл	600.000	600.000
3.	Заал талбайн түрээс /үзель/ хөтлөгч	1000.000	1000.000
4.	Медаль, чимэглэл видео бичлэг	300.000	300.000
ДҮН:		2.900.000	2.900.000